

1 НҮБ-ын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага – Монгол Улс ДАХЬ САЛБАР

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОХ УРИЛГА

1 Хэрэгжүүлэх хугацаа

Сонгон шалгаруулалтын оролцох урилга #	
Зарласан өдөр	9/5/2022
Асуулт хүлээн авах эцсийн хугацаа	25/5/2022
Матерал хүлээн авах эцсийн хугацаа	30/5/2022
Сонгон шалгаруулалтын дүн танилцуулах хугацаа	5/6/2022
Хэрэгжүүлж эхлэх хугацаа	15/6/2022
Хэрэгжүүлж дуусах хугацаа	15/12/2022

2 Байршил

ОУШХБ-ын төсөлд хамрагдаагүй дараах аймгуудын төрийн бус байгууллагууд материал ирүүлвэл давуу тал болно:

Ховд, Булган, Сэлэнгэ, Өвөрхангай, Төв, Хэнтий, Сүхбаатар, Дундговь, Өмнөговь, Дорноговь, Говьсүмбэр.

Энэхүү сонгон шалгаруулалтын урилгын санхүүжилт баталгаажсан тохиолдолд дээрх аймгуудаас 5 төрийн бус байгууллага нэмж сонгон шалгаруулах бөгөөд Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага энэ урилгыг хүссэн үедээ цуцлах эрхтэй.

3 Мэргэшсэн салбар(ууд) болон чиглэл(үүд).

Дотоодын шилжилт хөдөлгөөн

4 Хэрэгжүүлэгч агентлаг

НҮБ-ын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага

5 Үндсэн мэдээлэл

НҮБ-ын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нийслэлийн засаг даргын тамгын газар, Үндэсний статистикийн хороо, Улсын бүртгэлийн ерөнхий газар, аймгуудын Засаг даргын тамгын газар, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран дөрвөн жилийн хугацаатай “Монгол дахь дотоодын шилжилт хөдөлгөөнийг ойлгож, удирдах нь” төслийг 2019 оны 9 дүгээр сард хэрэгжүүлж эхэлсэн. Тус төсөл нь Швейцарын хөгжлийн агентлаг санхүүжилттэй 1) Дотоод шилжилт хөдөлгөөний тоон мэдээлэл; 2) Дотоод шилжилт хөдөлгөөний засаглал; болон 3) Зорилтот оролцоо бүхий гурван үндсэн бүрэлдэхүүн хэсэгтэй. Эдгээр үр дүн нь мэдээлэл, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нотолгоонд суурилсан, шилжилт хөдөлгөөнийг тусгасан бодлого, бодит оролцоогоор дамжуулан Монгол Улсын дотоодын шилжин суурьшигчдын нийгэм, эдийн засгийн байдлыг сайжруулах зорилтод хүрэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

Эхний үр дүн буюу дотоод шилжилт хөдөлгөөний талаарх тоон мэдээлэл нь дотоод шилжилт хөдөлгөөний талаарх бодлого боловсруулахад шаардагдах сүүлийн үеийн тоон мэдээлэл болон дүн шинжилгээнд гарч байгаа зөрүүг арилгахад чиглэнэ. Монгол Улсын хөгжилд тодорхой хувь нэмэр үзүүлдэг дотоод шилжилт хөдөлгөөний засаглалыг дэмжих зорилгоор шилжилт хөдөлгөөний хэтийн төлөв, дотоодын шилжин суурьшигчдад тулгамдаж буй хэрэгцээ шаардлагыг цогц, харилцан уялдаа холбоотой бодлого, хөтөлбөрүүдтэй зүй зохистой байдлаар нэгтгэн уялдуулах нь тус хөтөлбөрөөс гарах хоёр дахь үр дүн юм. Дотоодын шилжилт хөдөлгөөний талаарх өргөн хүрээтэй мэдлэг, мэдээллийг оролцогч талуудад олгож, улмаар богино, дунд, урт хугацаат бодлогын хариу арга хэмжээний талаар бие даасан зөвлөмжүүд бүхий Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулснаар Монгол Улсын Засгийн газар нь дотоодын шилжин суурьшигчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн үр дүнтэй хариу арга хэмжээ авах, дотоод шилжилт хөдөлгөөнийг бодлого төлөвлөлт, хариу арга хэмжээнд чиглүүлэхэд шаардлагатай арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх боломжтой болно.

Гурав дахь үр дүнгээр мэдээлэл, үйлчилгээ, зорилтот арга хэмжээний хүртээмжийг сайжруулах замаар дотоодын шилжин суурьшигчдын эмзэг байдлыг багасгах зорилготой. НЗДТГ, иргэний нийгмийн байгууллагууд, үндэсний хэмжээний болон орон нутгийн түвшиний засаг захиргааны байгууллагууд (хороо, аймаг, сумын ЗДТГ)-тай нягт хамтарч ажиллана. Улаанбаатар хотын шилжин суурьшигчид, хөдөө орон нутгаас шилжилт хөдөлгөөн хийхээр төлөвлөж байгаа иргэдэд шилжилт хөдөлгөөн хийх шийдвэр гаргахаасаа өмнө мэдээлэлтэй байх зорилго бүхий Мэдээллийн компани ажлыг улс орон даяар амжилттай зохион байгуулсан.

Төслийн 3.3 дугаар хэсэгт тусгасны дагуу тус төсөл нь шилжилт хөдөлгөөн, ялангуяа шилжин суурьшиж буй эмэгтэйчүүдэд хамаатай мэдээлэл, үйлчилгээг үзүүлэх ТББ-уудын чадавхыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх болно. Энэхүү хэсэг нь Улаанбаатар болон аймгуудын хязгаарлагдмал чадавхи, нөөц бүхий хороод, орон нутгийн байгууллагад дэмжлэг үзүүлэх, улмаар Улаанбаатар хот болон цаашилаад дотоодын шилжин суурьшигчид, хөдөө орон нутагт шилжилт хөдөлгөөн хийх хүсэлтэй шилжин суурьшигчдад чиглэсэн зөвлөгөө, мэдээллээр хангах зорилготой.

Тэтгэлгийн үндэслэл, зорилго

Энэхүү тэтгэлгийн үндэслэл, зорилго нь дотоодын шилжин суурьшигчдыг эдийн засгийн хувьд чадавхижуулах, хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, шаардлагатай нөхцөлөөр хангах замаар орон нутгийн хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан тодорхой элементүүдийг хэрэгжүүлэхэд орон нутгийн удирдлага, төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг идэвхжүүлж, нөөц бололцоогоор хангах, шаардлагатай мэдээлэл, нийгэм-сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэхэд оршино.

Ерөнхий хандлага нь орон нутгийн ТББ-ууд орон нутгийн хөгжлийн зорилтыг хангахын зэрэгцээ үйлчилгээ үзүүлэх дарамтыг арилгах, шинэлэг арга зүй, чадавхи, хэрэгжүүлэх уян хатан байдал гэх мэтээр орон нутгийн төрийн захиргааг дэмжих явдал юм.

Зорилтууд

1. Одоо байгаа болон ирээдүйд шилжин суурьшихаар төлөвлөж байгаа иргэдийн мэдлэгийн түвшинг дээшлүүлэх, аюулгүй шилжилт хөдөлгөөн, боломжит төрийн үйлчилгээний талаарх мэдээллээр хангах
2. Нийгэм сэтгэлзүйн дэмжлэг болон бусад үйлчилгээний хүртээмж багатай, гадуурхагдсан шилжин суурьшигчдад нийгэм сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх
3. Үндэсний хэмжээнд хэрэгжих боломжтой үйл ажиллагаануудыг боловсруулж, турших
4. Үндэсний бодлогыг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээл, саад бэрхшээл зэргийг тодорхойлж, засч залруулах/сайжруулах зөвлөмж өгөх
5. Иргэний нийгмийн институцийг орон нутгийн түвшинд бэхжүүлж, Орон нутгийн төрийн байгууллагуудтай хамтран ажиллана

Энэ төслийн гол зорилтот бүлэг бол шилжин суурьшсан иргэд , Улаанбаатар хот руу болон бусад аймаг болон сум руу шилжин суурьшихаар төлөвлөж байгаа иргэд болно. Зорилтот бүлэг дунд шилжилт хөдөлгөөний явц дунд орхигддог эмэгтэйчүүд болон залуучууд руу төвлөрөн ажиллахыг дэмжиж байна. Дотоодын шилжилт хөдөлгөөнд оролцогч гэдгийг тухайн хүн, айл өрх оршин суугаа газраа 6 сараас дээш хугацаагаар засаг захиргааны өөр нэгж рүү шилжин суурьшсан иргэдийг хамруулан ойлгоно.

Дотоодын шилжин суурьшигчдад тогтвортой ажлын байр, нийгэм сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх замаар эдийн засаг, нийгмийн интегралчлал тал дээр дэмжлэг үзүүлсэн ажилласнаар шилжих хөдөлгөөнд оролцогч нь хувь хүн болон гэр бүлдээ, тухайн амьдрахаар зорьж буй газартаа тодорхой ахиц дэвшилийг авчирдаг гэж үздэг байна.

Орон нутгийн төрийн бус байгууллагуудтай хамтран ажилласан төслийн эхний шат

2021 оны 4-р сараас 9-р сарын хооронд төслийн эхний шатыг хэрэгжүүлсэн. Эхний шатанд 11 аймгийн 17 төрийн бус байгууллага шалгарсан. Эхний шатанд НҮБ-ын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага нь Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд Хөдөлгөөнийг (НДЭХ) шүхэр төрийн бус байгууллагаар сонгон шалгаруулсан бөгөөд болон дотоодын шилжин суурьшигчдад үйлчилгээ үзүүлэх орон нутгийн ТББ-уудыг сонгон гэрээ байгуулж, сонгогдсон орон нутгийн ТББ-уудад дэмжлэг үзүүлэх, чадавхижуулах хэд хэдэн арга хэмжээг хэрэгжүүлсэн. Мөн сонгогдсон ТББ-уудын сүлжээний стратегийг боловсруулж 2021 оны 4-9 дүгээр сард 6 сарын хугацаатай “Орон нутгийн ТББ-уудын жижиг төслүүдээр дамжуулан шилжин суурьшигчдын эмзэг байдлыг хязгаарлах нь” төслийг НҮБ-ын Шилжилт Хөдөлгөөний Байгууллагатай хамтран амжилттай хэрэгжүүлж дуусгаад байна. Төслийн хүрээнд НДЭХ болон орон нутгийн ТББ-ууд ажлын байран дээрх үйл ажиллагааны удирдамж, Мэдээллийн өдрүүдийг хэрэгжүүлэх үзэл баримтлалыг боловсруулж, шилжин суурьшигчдад нийгэм сэтгэлзүйн үйлчилгээг үзүүлэх туршилтын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлсэн, мөн MigNet буюу орон нутгийн төрийн бус байгууллагуудын сүлжээний үзэл баримтлыг боловсруулсан.

Төслийн эхний шатанд орон нутгийн болон Улаанбаатарын 17 ТББ-уудад чадавх бэхжүүлэх сургалт, шилжин ирэгсдэд тулгамдаж байгаа эмзэг байдлыг багасгах зорилгоор мэдээллээр хангах, сэтгэлзүйн дэмжлэг, зөвлөгөө өгөх, нэн шаардлагатай суурь үйлчилгээнд хамруулахад чиглэсэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн.

Орон нутгийн ТББ-ууд дараах ажлуудыг хэрэгжүүлсэн. Үүнд:

- Сэтгэлзүйн дэмжлэг (Зөвлөгөө, сэтгэлзүйн дэмжлэг, шууд дэмжлэг туслалцаа);
- Ганцаарчилсан уулзалт яриа хийх замаар мэдээллээр хангах, шилжин суурьшигчдыг төвүүдэд хүлээн авах, цахимаар болон шууд утсаар мэдээлэл өгөх;
- Баримт бичиг, бүртгэл: Шилжин суурьшигчдыг бүртгэлжүүлэх, бүртгэлийн алдаа, баримт бичигтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх;
- Ажил хөдөлмөр эрхлэх боломжоор хангах: ТББ-уудын тусламж дэмжлэгтэйгээр шилжин суурьшигчид нь ажлын байраар хангагдаж, жижиг бизнес эрхэлж эхэлсэн;

Эдгээр ажлуудын үр дүнд орон нутгийн төрийн бус байгууллагууд нийт 10,603 (5,860 эмэгтэй, 4,743 эрэгтэй) зорилтот бүлгийн шилжин суурьшигчдад шилжилт хөдөлгөөнтэй холбоотой шууд үйлчилгээ үзүүлсэн. Төслийн хүрээнд хөдөө орон нутаг болон хот суурин газрын 200 мянга гаруй шилжин суурьшигчдад дасан зохицол, бүртгэл, бичиг баримтжуулах, чадавхижуулах болон шилжилт хөдөлгөөнтэй холбоотой бусад асуудлаар 10 мэдээллийн өдөрлөгөөр дамжуулан мэдээллийг нэмэгдүүлсэн байна.

Орон нутгийн төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах төслийн хоёрдугаар шат

Төслийн хоёрдугаар шатны сонгон шалгаруулалт 2021 оны 11-р сарын 18-нд 21 хоногийн хугацаанд зарласан бөгөөд 23 төрийн бус байгууллага материал ирүүлснээс 9 аймгийн 13 төрийн бус байгууллага шалгарсан. Энэ үеэр үйл ажиллагаа, төсвөө тодорхой болгож, гэрээ байгуулсан ба Орхон, Завхан зэрэг аймгуудын ТББ-уудад сургагч багш бэлтгэх сургалтыг 2 удаа зохион байгуулсан ба төслийн үйл ажиллагаа үргэлжилж байна.

6. Тэтгэлэгийн бүтэц

2021 оны 11-р сараас 12-р сард хийгдсэн Дотоодын шилжилт хөдөлгөөнийг ойлгож, удирдах нь төслийн дунд хугацааны үнэлгээний зөвлөмжийн дагуу орон нутгийн ТББ-уудтай хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагаа нь өндөр үр дүнтэй болохыг тогтоож, сунгахыг зөвлөсөний дагуу энэхүү сонгон шалгаруулалтын урилга нь ОУШХБ-ын орон нутгийн ТББ-уудтай хамтран хэрэгжүүлж буй хөтөлбөрийн хоёр дахь шатанд хамтран ажиллаж буй орон нутгийн ТББ-уудын тоог нэмэх зорилготой нэмэлт урилга юм

Шилжилт хөдөлгөөний талаар тодорхой түвшиний ойлголттой, нэн шаардлагатай үйлчилгээ үзүүлэх шинэлэг, үр дүн бүхий төлөвлөгөөтэй, шилжин суурьшигчдад дэмжлэг туслалцаа үзүүлэх, орон нутгийн засаг захиргаанд дэмжлэг үзүүлэх, чадавх, туршлагатай орон нутгийн ТББ-уудыг урьж байна. Шилжилт хөдөлгөөн, түүнтэй холбоотой үйлчилгээ үзүүлсэн туршилага болон тус тэтгэлгийн зорилго, зорилтыг харгалзан дараах бүтэц бүхий төслийн саналтай байгууллагууд хамтран ажиллах саналаа ирүүлнэ үү.

- I. **Эдийн засгийн бүрэлдэхүүн хэсэг** (хүсэлт гаргагчийн төсөвт тусгах): шилжин суурьшсан болон шилжин ирэхээр төлөвлөж байгаа иргэдэд эдийн засгийн чадавхтай болох хөдөлмөр эрхлэх чадамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа: Явуулах боломжтой үйл ажиллагаа гэдэгт шилжин суурьшигчдад зориулсан ажилтай болох, зээл авах, бизнес эхлүүлэх зэрэг боломжуудын талаар мэдээлэл өгөх сургалт, семинар зохион байгуулах, зээлийн хөтөлбөрт хамрагдахад нь дэмжлэг үзүүлэх, тухайлбал маркетинг, нягтлан бодох бүртгэлийн тал дээр дэмжлэг болохуйц мэргэжлийн туслалцаа үзүүлэх зэрэг болно. Мөн шилжин суурьшигчдад энэхүү дурьдсан зөвлөгөө өгөх зэрэг бүхэлдээ тогтвортой ажил хөдөлмөр эрхлэх, бизнесийн үйл ажиллагаа эрхлүүлэхэд чиглэсэн ажлууд багтах ба өөр нэмэлт ажлууд байж болно.
Үндсэн шалгуур: сургагдсан хүний тоо, чадавхыг бэхжүүлэх чиглэлээр мэдлэгээ дээшлүүлсэн хүний тоо, ажилд орсон хүний тоо, бизнес эхлүүлсэн хүний тоо
- II. **Мэдээлэл, НСД үзүүлэх бүрэлдэхүүн хэсэг** (төсвийг хүсэлт гаргагч боловсруулна): шилжин суурьшигчид болон шилжин ирэхээр төлөвлөж байгаа иргэдэд зайлиггүй шаардлагатай бусад мэдээлэл, үйлчилгээгээ үзүүлэх үйл ажиллагаа. Шилжин суурьшсан иргэд болон ирэх хүсэлтэй иргэдэд тулгамдаж байгаа бэрхшээлт байдлыг бууруулах, түүнчлэн тогтвортой ажил хөдөлмөр эрхлэх, бизнесийн үйл ажиллагаа явуулахад нь чиглэсэн эдийн засгийн бүрэлдэхүүн хэсэгт гаргах ахиц дэвшилд дэмжлэг үзүүлэх нь эдгээр үйл ажиллагааны зорилго юм. Уг ажлын хүрээнд ОУШХБ-ын заасан өдрүүлдэд орон даяар **хоёр удаагийн Мэдээллийн өдөрлөгийг** зохион байгуулна. Бүх сонгогдсон орон нутгийн ТББ-ууд, болон НҮБ-ын Шилжилт Хөдөлгөөний Байгууллагатай хамтарч төслийн хэрэгжилтийн эхэн болон дунд үед тодорхой өдрийг сонгоно. Ингэхдээ шилжилт хөдөлгөөн хийсэн болон хийхээр төлөвлөж байгаа газрын ажил хөдөлмөр, бизнес эрхлэх боломжууд, нэн шаардлагатай зөвлөгөө зөвлөмжүүдийг нэгтгэсэн байдлаар хүргэх ба нийгэм сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ хэд хэдэн үйл ажиллагааг нэгэн зэрэг хэрэгжүүлнэ. Хоёр дахь Мэдээллийн өдөрлөг нь орон нутгийн эрэлт хэрэгцээнд илүү нийцсэн, төслийн дөрөвдүгээр хэсгийн хүрээнд хийсэн судалгаа зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх ёстой.
- III. **Боломжит ажлыг хэрэгжүүлэх бүрэлдэхүүн хэсэг** (төсвийг хүсэлт гаргагч боловсруулна): Дөрөвдүгээр бүрэлдэхүүн хэсэгт заасан судалгаа шинжилгээний зөвлөмжийг хэрэгжүүлэхэд дэмжлэг болох үйл ажиллагаанд нийт зарцуулах төсвийн 10%-20%-ийг төсөвлөхийг санал болгож байна.
- IV. **Судалгаа шинжилгээний бүрэлдэхүүн хэсэг** (ТББ болон орон нутгийн төрийн байгууллагуудын дэмжлэгтэйгээр хийх тул төсөв шаардагдахгүй): НҮБ-ын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага нь сонгогдсон орон нутгийн ТББ-ууд, ОНТБ-уудтай үйл ажиллагааны зорилтот бүс нутагт судалгаа шинжилгээ явуулахад нь бусад түнш байгууллагуудтай хамтран ажиллана. НҮБ-ын Шилжит Хөдөлгөөний Байгууллага нь ерөнхий арга зүйг боловсруулан хангах, сургалт зохион байгуулах, тоон мэдээлэл цуглуулах, мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд дэмжлэг үзүүлэн ажиллана. Орон нутгийн ТББ нь орон нутгийн төрийн байгууллагатай хамтарч судалгаа шинжилгээ явуулах, шаардлагатай мэдээлэл цуглуулах, ба судалгаа шинжилгээнээс гарсан зөвлөмжүүдийн хэрэгжилтийг мөрдүүлнэ.

Тэтгэлгийн хүрээнд санал болгож буй арга хэмжээг тухайн орон нутгийн ТББ болон ОНТБ хамтран боловсруулж, орон нутгийн төрийн байгууллагын зүгээс санхүүгийн хувьд 30% -с доошгүй хувийн санхүүгийн дэмжлэг үзүүлэн дэмжин ажиллахаа төсөвт тусгасан байх шаардлагатай. Түүнчлэн тухайн үйл ажиллагаа,

арга хэмжээг тухайн орон нутгийн төлөвлөгөө, стратегид нийцүүлж уялдуулсан байх. Хүсэлт гаргагч ТББ-ууд нь аймаг, сумын удирдлагуудаас хамтран ажиллах дэмжлэг авсан байх ба аймгийн төвүүдийн гэр хороололд шилжин ирэгсдийн төвлөрөл их, эмзэг байдалд өртөөж байгаа байдал зэрэг хангалттай үндэслэл байгаа тохиолдолд багийн удирдлагуудтай хамтран ажиллахыг зөвшөөрнө.

Үйл ажиллагаа явуулах арга барил

Сонгогдсон ТББ-ууд орон нутгийн төрийн байгууллагатай нягт хамтран ажиллах ба ерөнхий менежментийг хийх НҮБ-ын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага нь үндэсний болон орон нутгийн хэмжээний бүх талын бодит түншийн туслалцаа дэмжлэгээр хангах үүрэг хүлээнэ. Төслийн хоёрдугаар шатанд шүхэр төрийн бус байгууллага байхгүй.

Зорилтот өгөөж хүртэгчид

Үндсэн зорилтот бүлэг:

- Одоо байгаа шилжин суурьшигчид: 6 сараас 7 жил хүртэл хугацаанд амьдарч байгаа
- Ирээдүйн шилжин суурьшигчид: ойрын хугацаанд буюу 03 сараас 1 жилийн дотор шилжилт хөдөлгөөн хийхээр төлөвлөж байгаа иргэд

Одоо байгаа болон ирээдүйд шилжих хүсэлтэй иргэд түүн дотроо эмэгтэйчүүд, хүүхдүүд, залуучуудад чиглэж ажиллана.

Дараагийн зорилтот бүлэг:

- Орон нутгийн ТББ-ууд дотоодын шилжин суурьшигчдад дэмжлэг үзүүлэхэд анхаарал хандуулах, идэвхжүүлэх зорилгоор үйл ажиллагааны дийлэнх хэсгийг зарим тодорхой аймгууд, Нийслэлийн дүүрэг, хороодод төвлөрч явуулна.
- Орон нутгийн төрийн байгууллага нь төвлөрлийг сааруулахад чиглэсэн төрийн үйлчилгээг тус тэтгэлгийн хүрээнд хамруулан ажиллах бүрэн боломжтой.

Энэхүү тэтгэлэг нь засаг захиргааны анхан шатны нэгжээс дээд түвшний нэгжид эсхүл ижил түвшний нэгж рүү (сумаас аймгийн төв рүү эсхүл Улаанбаатар руу) чиглэсэн шилжилт хөдөлгөөнд төвлөрөх боловч буцах шилжилт хөдөлгөөн, ялангуяа Улаанбаатар хотоос хөдөө орон нутаг руу шилжин суурьшсан эсхүл шилжин суурьших хүсэлтэй иргэдийг мөн хамрах болно.

Тэтгэлгийн үйл ажиллагаа

Орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх зорилтот арга хэмжээ нь орон нутгийн шилжилт хөдөлгөөний нөхцөл байдалаас хамаарч харилцан адилгүй байдаг тул хүсэлт гаргагчид орон нутгийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн үйл ажиллагааг санал болгох нь зүйтэй.

Орон нутгийн нөхцөл байдал, шаардлагаас хамаарч ТББ-уудын хэрэгжүүлж болох үйл ажиллагаануудад:

- Зайлшгүй шаардлагатай мэдээллээр хангах, олон нийтийг хамарсан арга хэмжээ / нээлттэй хаалганы өдөрлөг, мэдээллээр хангах аян;
- Шилжин суурьшигчдад зориулсан зайлшгүй шаардлагатай үйлчилгээнд хамруулах, дэмжлэг үзүүлэх
- Нийгэм сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх;
- Хэрэгцээ шаардлагад нь нийцсэн богино хугацаат сургалтууд зохион байгуулах;
- Ажлын байр бий болгох төслүүд, шилжин суурьших, шилжилт хөдөлгөөн хийх бүс нутагт жижиг бизнес эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүд хэрэгжүүлэх;
- Угтах үйлчилгээ үзүүлэх ажлууд багтана.

Жич: Санал болгож буй эдгээр үйл ажиллагааг заавал оруулах албагүй ба тухайн орон нутаг, аймаг, сум, дүүрэг, хорооны нөхцөл байдал, онцлогт тохируулж болно.

7 **Тэтгэлэг олгох хугацаа**

Тус төсөл нь 2022 оны 6 дугаар сарын 15-наас эхлэн 6 сарын хугацаанд хэрэгжинэ.

Энэхүү сонгон шалгаруулалтын урилгын санхүүжилт баталгаажсан тохиолдолд төсөл хэрэгжүүлэх бөгөөд Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага энэ урилгыг хүссэн үедээ цуцлах эрхтэй.

8. **Хүсэлт гаргах ТББ-д тавигдах шалгуур:**

- Монгол Улсад бүртгэлтэй, санал болгож буй бүх үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх зүйн чадамжтай;
- Зорилтот бүлэгтэй ажиллаж байсан туршилагатай байх, дотоодын шилжин суурьшигчидтай ажиллаж байсан бол давуу тал гэж үзнэ;
- Орон нутгийн төрийн байгууллага, үндэсний болон орон нутгийн ТББ-ууд, бусад байгууллага, хувь хүмүүстэй түншлэлийг бий болгож, хамтран ажиллаж байсан туршилагатай байх.

Хүсэлт гаргагч ТББ нь:

- Тус төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай чадварлаг, мэргэшсэн багийн гишүүдтэй байх;
- НҮБ-ын Шилжилт Хөдөлгөөний Байгууллагатай хамтран ажиллаж байсан туршилагатай бол давуу тал болно. Өмнө нь хамтран ажиллаж байсан бол үйл ажиллагааг үр дүнтэй, тайлагнаж байсан сайн түүхтэй байх. Төсөл дууссаны дараа орон нутгийн төрийн байгууллагуудтай хамтран тус төслийг үргэлжлүүлэх төлөвлөгөө, бололцоотой байх;
- Орон нутгийн төрийн байгууллагатай хамтран ажиллах, санхүүжилтийг баталгаажуулсан байх;
- НҮБ-ын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага тэргүүлж байгаа дотоод шилжилт хөдөлгөөний чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг орон нутгийн ТББ-уудын Сүлжээнд нэгдэн идэвхтэй үйл ажиллагаа явуулах зорилготой байх;
- Дотоод шилжилт хөдөлгөөний чиглэлээр хэрэгжиж байгаа нэгдмэл зорилгуудыг дэмжих бусад үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;
- НҮБ-ын Шилжилт хөдөлгөөний байгууллагатай бүх талаар хамтран ажиллах, хугацаат ажлыг хугацаанд нь гаргаж өгөх, зайлиггүй шаардлагатай бүх мэдээллийг хугацаанд нь ирүүлэх.

Сонгон шалгаруулах явц

1-р шат: Хүсэлт гаргагчийг тогтоосон шалгуурын дагуу урьдчилсан байдлаар үнэлгээ хийж шалгаж, сүүлийн шатны жагсаалтын сонгон шалгаруулалтыг хийнэ.

2-р шат: Сүүлийн шатны жагсаалтад багтсан ТББ-уудтай, шаардлагатай бол орон нутгийн төрийн байгууллагын төлөөлөгчтэй ярилцлага хийнэ.

3-р шат: Эцсийн дүнг зарлана.

4-р шат: **Магадлан шалгалтын** дараа сонгогдсон орон нутгийн ТББ-ууд гэрээ хийж **Ашиг сонирхлын зөрчилгүй байдлын батламж** болон **Хамтран ажиллах гэрээнд** гарын үсэг зурна. Өргөдөлд үнэлгээ өгөхдөө дараах шалгуурыг баримтална. Үүнд: Хүсэлт гаргагч ТББ-ын туршлага (орон нутгийн төрийн байгууллагатай хамтран зорилтот бүлэг, шилжин суурьшигчдыг хамарсан ижил төстэй төсөл хэрэгжүүлсэн туршлагыг харна)

1. Тэтгэлэг авахаар санал болгож буй төслийн хамаарал, үр өгөөж, үр ашиг, тогтвортой байдлыг сайтар бодож боловсруулсан байх, санал болгож буй арга хэмжээг уялдаа холбоотой нэгтгэсэн байх;
2. Санал болгож буй төслийн тооцоолсон нөлөөлөл: хэр хүчтэй / эрчимтэй өөрчлөгдөх үр дүн гарах вэ (чанарын хэмжигдэхүүн), хэр олон хүний амьдрал ахуй илүү сайн сайхнаар өөрчлөгдөх вэ (тоон хэмжигдэхүүн);

Орон нутгийн төрийн байгууллагаас хамтран ажиллах, дэмжлэг туслалцааны үр дүнтэй байдлыг харгалзан харна.

Ирүүлэх материал:

Хөдөө орон нутаг (аймгууд)-ын гэр хороололд төвлөрч үйл ажиллагаа явуулах ТББ-уудыг хүсэлт гаргахыг урьж байна.

Орон нутгийн ТББ-ууд нь НҮБ-ын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага, түүний түнш байгууллагуудаас зохион байгуулах чадавхжуулах цуврал сургалтад хамруулахаас гадна төсөл хэрэгжүүлэхэд нь цогц байдлаар дэмжлэг үзүүлэн ажиллана.

Сонирхож буй ТББ-ууд хүсэлтээ дараах форматаар цахим хаягаар болон цаасан хэлбэрээр ирүүлнэ үү.

- Загвар А: **ТББ-ын танилцуулга болон Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар**
- Загвар Б: **Оролцох сонирхлоо илэрхийлсэн хүсэлт**, Сүүлийн үеийн шилжилт хөдөлгөөний нөхцөл байдал болон төслийн хүрээнд шийдвэрлэх шилжилт хөдөлгөөнтэй холбоотой тодорхой асуудал оруулсан байх, үйл ажиллагааны үндэслэл, зорилго, зорилтууд, үйл ажиллагааны төлөвлөгөө; төслийн үйл ажиллагаа болон ОНТБ-ын стратеги хоорондын уялдаа холбоо, үйл ажиллагааны төлөвлөгөө;
- Загвар В: **Гүйцэтгэлийн үзүүлэлт, зорилтыг хянах, үнэлэх аргачлал;**
- **Орон нутгийн төрийн байгууллагаас (ОНТБ) ирүүлэх тодорхойлолт:** Ирүүлсэн төслийг орон нутгийн ТББ, ОНТБ хамтран боловсруулсан бөгөөд ОНТБ нь төсөл хэрэгжүүлэхэд бүрэн дэмжлэг туслалцаа үзүүлж, идэвхтэй оролцож, төсөвт заасан хамтарсан санхүүжилтийг гаргах болно гэдгийг баталж тухайн ОНТБ гарын үсгээр баталгаажуулсан тодорхойлолтыг Монгол Улс дахь НҮБ-ын Шилжилт Хөдөлгөөний Байгууллагад хаяглан ирүүлнэ.
- Загвар Г: **Төсөв:** НҮБ-ын Шилжилт Хөдөлгөөний Байгууллагаас өгсөн Excel хүснэгттэй загварыг ашиглана уу (тус хүснэгтэд ОНТБ-ын хамтарсан санхүүжилтийн тусдаа баганыг багтаасан байна).
- Загвар Д: **Төсөл хэрэгжүүлэгчийн ерөнхий мэдээлэл /асуулга/**

9 **Хүсэлт хүлээн авах эцсийн хугацаа**

Төслийн саналыг 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрөөс өмнө iomubadminhr@iom.int цахим хаягаар болон цаасан хэлбэрээр дараах шуудангийн хаягаар илгээнэ үү:

Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага, Нэгдсэн Үндэстний Байгууллага, Нэгдсэн Үндэстний гудамж-14, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14201.

Төслийн саналын бүтэн хувилбарыг <https://mongolia.iom.int/> цахим хуудаснаас авах боломжтой.

Нэмэлт мэдээлэл, тодруулга авахыг хүсвэл 2022 оны 05 дугаар сарын 25-ний өдрөөс өмнө Үндэсний хөтөлбөрийн ажилтан Ю.Оюунхишиг 99100804, Төслийн ажилтан Б.Халиун 99078811 дугаараар холбогдоно уу. .

ХҮСЭЛТ ИРҮҮЛЭХ СҮҮЛЧИЙН ХУГАЦАА: 2022 оны 05 дугаар сарын 30-ний өдрийн 18:00 цаг

10 **СОНГОН ШАЛГАРУУЛАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Нэр	Тайлбар	Жин
-----	---------	-----

<p>Хүлээгдэж буй үр дүнд хүрэхэд ирүүлсэн төсөл нийцэж байгаа эсэх</p>	<p>Зорилтот бүлгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн төслийн санал боловсруулсан байх</p> <p>Хүлээгдэж буй үр дүн тодорхой, хэмжигдэхүйц, шалгуур үзүүлэлттэй байх</p> <p>Орон нутгийн төрийн байгууллагаас санхүүгийн болон үйл ажиллагааны дэмжлэгтэй байх</p> <p>Цаашид бусад орон нутаг, дүүрэгт хэрэгжүүлэх боломжтой байх</p> <p>Санал болгож буй төсөв хангалттай ойлгомжтой байх, харилцан хамааралтай, хэрэгжүүлэх үйл ажиллагаатай нягт уялдсан байх</p>	<p>60</p>
<p>Үйл ажиллагааны тогтвортой байдал</p>	<p>Орон нутгийн төрийн байгууллагуудтай хамтран ажиллах чадвартай байх, цаашид хамтран ажиллах идэвх эрмэлзэлтэй</p> <p>Өмнө төсөл амжилттай хэрэгжүүлж байсан туршлагатай, төслийн тогтвортой байдлын талаар тодорхой ойлголттой байх</p>	<p>20</p>
<p>Бусад</p>	<p>Хөтөлөргөрийг хэрэгжүүлэх явцад жендерийн тэгш байдлыг хангах, шинэлэг</p>	<p>20</p>

10 ХАВСРАЛТУУД

Description
<p>Загвар А: ТББ-ын танилцуулга болон Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар</p>
<p>Загвар Б: Оролцох сонирхлоо илэрхийлсэн хүсэлт, Сүүлийн үеийн шилжилт хөдөлгөөний нөхцөл байдал болон төслийн хүрээнд шийдвэрлэх шилжилт хөдөлгөөнтэй холбоотой тодорхой асуудлуудын тайлбар, үйл ажиллагааны үндэслэл, зорилго болон зорилтууд, төлөвлөсөн үйл ажиллагаа;</p> <ul style="list-style-type: none"> ○ Төслийн үйл ажиллагаа болон ОНТБ-ын стратеги хоорондын уялдаа холбоо, үйл ажиллагааны төлөвлөгөө;
<p>Загвар В: Гүйцэтгэлийн үзүүлэлт, зорилтыг хянах, үнэлэх аргачлал;</p>
<p>Орон нутгийн төрийн байгууллагаас (ОНТБ) ирүүлэх тодорхойлолт</p>
<p>Загвар Г: Төсөв</p>

Загвар Д: Төсөл хэрэгжүүлэгчийн ерөнхий мэдээлэл /асуулга/

12 ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ АВАХ, ӨРГӨДӨЛ ГАРГАХ ТАЛААР МЭДЭЭЛЭЛ АВАХЫГ ХҮСВЭЛ ДООРХ ХАЯГААР ЗОЧИЛНО УУ

<https://mongolia.iom.int/>

Энэхүү урилгыг хүлээн авч буй байгууллагууд жагсаалтад дурьдсан үйл ажиллагаануудыг нэг багц болгоно. Хувь хүний илгээсэн өргөдлийг хүлээн авахгүй.

ОУШХБ нь төлөвлөсөн үйл ажиллагааны цар хүрээг цуцлах/багасгах эсвэл шинээр хэрэгжүүлэх/үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх эрхтэй. Сонгогдсон хэрэгжүүлэгч түнш ОУШХБ -аас мэдэгдлийг хүлээн авснаас хойш хоёр долоо хоногийн дотор ирүүлсэн саналд үндэслэн нарийвчилсан төсөв боловсруулахад бэлэн байх ёстой.

Сонгон шалгаруулалтын үр дүнгийн талаарх төслийн материал хүлээн авснаас хоёр долоо хоногийн дотор бүх өргөдөл гаргагчид цахим шуудангаар мэдэгдэнэ. Өргөдөл гаргагч төслийн сонгон шалгаруулалтын явцын талаар нэмэлт тодруулга авах хүсэлт гаргавал ОУШХБ-аас сонгон шалгаруулалтын явц болон үр дүнгийн талаар тайлбар тавина.

ОУШХБ нь сонгон шалгаруулалтын шийдвэрийн талаарх нууцлалын зэрэгтэй мэдээлэл өгөхөөс татгалзах эрхтэй.

ОУШХБ нь аливаа төслийн саналыг хүлээн авах болон татгалзах бүрэн эрхтэй. Мөн сонгон шалгаруулалтын урилгыг хүчингүй болгох эрхтэй бөгөөд хэрэгжүүлэгч байгууллагын өмнө хариуцлага хүлээхгүй.

Нэмэлт мэдээлэл авах бол (ОУШХБ-ын Үндэсний Төслийн Ажилтан Ю.Оюунхишиг), дараах и-мэйл хаягаар авах боломжтой (oyura@iom.int).

САНАЛ ХҮРГҮҮЛЭХ ЖУРАМ

Энэхүү баримт бичиг нь хавсралт А-д дурьдсан төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл, өгөгдлийг бэлтгэх , илгээх зааварчилгааг агуулна.

Өргөдлийг цаасан хэлбэрээр дараахь шуудангийн хаягаар Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагад хаяглан илгээнэ: Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага, Нэгдсэн Үндэстний Байгууллага, Нэгдсэн Үндэстний гудамж-14, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14201. Цахим хэлбэрээр [iomubadminhr@iom.int] хаягруу давхар илгээнэ. Материал хүлээн авах эцсийн хугацаа 05-р сарын 30, 2022. Хоцорсон материал хүлээн авахгүй.

1. Төсөл хэрэгжүүлэгч байгууллагууд, ОУШХБ-ын тавьсан шаардлагын дагуу байгууллагын туршлага, чадамж, судалгааны мэргэшсэн байдал, зэргийг хүргүүлнэ.
2. Өргөдлийн нэг эх хувь, нэг хуулбар хувийг дугтуйнд “Эх хувь” , “хуулбар хувь” гэсэн тэмдэглэгээтэй илгээнэ. Эх хувь болон хуулбар хувийн хооронд ямар нэгэн зөрүү үүсвэл, эх хувийг эх сурвалж болгон хэрэглэнэ. Дугтуйн дээр, буцах хаяг, өргөдөл тодорхойлолтын дугаар, төслийн нэр, хамтран хэрэгжүүлэгчийн (байгууллагын) нэр бичнэ.
3. Өргөдлийг монгол хэл дээр, ОУШХБ-аас заасан форматаар ирүүлнэ. Шаардлагатай бүх мэдээллийг ирүүлэх бөгөөд энэхүү шаардлагыг бүрэн хангаагүй бол татгалзаж болно.
4. Өргөдөлд хавсаргах баримт бичгүүд
 - a. Загвар А: **ТББ-ын танилцуулга, байгууллагын гэрчилгээний хуулбар**
 - b. Загвар Б: **Оролцох сонирхлоо илэрхийлсэн хүсэлт**, Сүүлийн үеийн шилжилт хөдөлгөөний нөхцөл байдал болон төслийн хүрээнд шийдвэрлэх шилжилт хөдөлгөөнтэй холбоотой тодорхой асуудлуудын талаар, үйл ажиллагааны үндэслэл, зорилго болон зорилтууд, төлөвлөсөн үйл ажиллагаа; төслийн үйл ажиллагаа болон ОНТБ-ын стратеги хоорондын уялдаа холбоо, үйл ажиллагааны төлөвлөгөөг багтаана;
 - c. Загвар В: **Гүйцэтгэлийн үзүүлэлт, зорилтыг хянах, үнэлэх аргачлал;**
 - d. **Орон нутгийн төрийн байгууллагаас (ОНТБ) ирүүлэх тодорхойлолт**
 - e. Загвар Г: **Төсөв**

f. Загвар Д: Төсөл хэрэгжүүлэгчийн ерөнхий мэдээлэл /асуулга/

g. Бусад шаардлагатай баримт бичгүүд

5. Өргөдлийг хүлээн авах хугацаанаас өмнө буцаах боломжтой. Өргөдөл хүлээн авах хугацаа хэтэрснээс хойш өргөдлийг буцаан олгохгүй.
6. Төсөлд өргөдөл илгээгч нь өргөдөлтэй гаргахтай холбоотой бүх зардлыг хариуцах бөгөөд ОУШХБ аливаа зардлыг хариуцахгүй.
7. Сонгон шалгаруулалтын урилгын хэрэгжилттэй холбоотой, өргөдөл, байгууллагын мэдээлэл, бичгээр болон амаар илэрхийлсэн аливаа мэдээлэл нууцлагдана. Төслийн хамтрагч нь ОУШХБ-аас зөвшөөрөл авалгүйгээр аливаа мэдээллийг гуравдагч этгээдэд дамжуулахыг хориглоно. Төслийн хамтран хэрэгжүүлэгч сонгон шалгаруулалтад тэнцсэн эсэхээс үл хамааран ОУШХБ-тай солилцсон мэдээллийн нууцыг чандлан хадгалах үүргийг хүлээнэ.
8. ОУШХБ нь төсөлд өргөдөл гаргасан бүх байгууллагын мэдээллийг, /санхүүгийн тоон мэдээлэл, өмчлөл, хувийн мэдээлэл/ зэргийг нууцлах үүргийг хариуцлагатайгаар хүлээнэ.
9. Төсөлд өргөдөл гаргагч нь, өргөдөл гаргасан хугацаанаас, ОУШХБ-д хүргүүлсэн мэдээллээ, үнэлүүлэх, төсөлд мэдээллэх зорилгоор хуваалцахыг зөвшөөрнө.
10. ОУШХБ нь төсөлд өргөдөл гаргагчдаас сонгон шалгаруулахдаа, журмын дагуу аливаа нөлөөллөөс ангид бие даан шийдвэр гаргах эрхтэй бөгөөд сонгон шалгаруулалтын аль ч үед үр дүнг өргөдөл гаргагчид мэдээллэх үүрэг хүлээхгүй.

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Хүснэгт 1 – Ерөнхий гүйцэтгэгчээр ажилласан сүүлийн гурван жилийн мэдээлэл

- Эхэлсэн сар / Жил
- Дууссан сар / Жил
- Санхүүжүүлэгч байгууллага / Хамтрах байгууллага
- Төслийн дэлгэрэнгүй
- Гэрээний дүн

Тайлбар (Шаардагдах баримт бичгүүдийг хавсаргах)

Хүснэгт 2 – Ижил төстэй төсөл хэрэгжүүлсэн туршлага

- Жил
- Санхүүжүүлэгч байгууллага / Хамтрах байгууллага
- Төслийн дэлгэрэнгүй
- Гэрээний дүн
- Тайлбар (Шаардагдах баримт бичгүүдийг хавсаргах)

Хүснэгт 3 – Багийн үндсэн гишүүд

- Нэр
- Мэргэжил
- Ажилласан жил

Байгууллагын төслийн хэрэгжилтэнд зориулсан дэлгэрэнгүй CV-г явуулах

Хүснэгт 4 – Шаардлагатай нэмэлт мэдээлэл (аль ч форматаар боломжтой)

Төслийн хамтран оролцогч байгууллагууд дээрх мэдээллийг бүрдүүлэн өгөх боломжтой.

НҮБ-ын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага – Монгол улс дахь салбар

Хийгдэх ажлын даалгавар #:

Танилцуулга

Ерөнхий мэдээлэл

НҮБ-ын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нийслэлийн засаг даргын тамгын газар, Үндэсний статистикийн хороо, Улсын бүртгэлийн ерөнхий газар, аймгуудын Засаг даргын тамгын газар, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран дөрвөн жилийн хугацаатай “Монгол дахь дотоодын шилжилт хөдөлгөөнийг ойлгож, удирдах нь” төслийг 2019 оны 9 дүгээр сард хэрэгжүүлж эхэлсэн. Тус төсөл нь Швейцарын хөгжлийн агентлаг санхүүжилттэй 1) Дотоод шилжилт хөдөлгөөний тоон мэдээлэл; 2) Дотоод шилжилт хөдөлгөөний засаглал; болон 3) Зорилтот оролцоо бүхий гурван үндсэн бүрэлдэхүүн хэсэгтэй. Эдгээр үр дүн нь мэдээлэл, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нотолгоонд суурилсан, шилжилт хөдөлгөөнийг тусгасан бодлого, бодит оролцоогоор дамжуулан Монгол Улсын дотоодын шилжин суурьшигчдын нийгэм, эдийн засгийн байдлыг сайжруулах зорилтод хүрэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

Эхний үр дүн буюу дотоод шилжилт хөдөлгөөний талаарх тоон мэдээлэл нь дотоод шилжилт хөдөлгөөний талаарх бодлого боловсруулахад шаардагдах сүүлийн үеийн тоон мэдээлэл болон дүн шинжилгээнд гарч байгаа зөрүүг арилгахад чиглэнэ. Монгол Улсын хөгжилд тодорхой хувь нэмэр үзүүлдэг дотоод шилжилт хөдөлгөөний засаглалыг дэмжих зорилгоор шилжилт хөдөлгөөний хэтийн төлөв, дотоодын шилжин суурьшигчдад тулгамдаж буй хэрэгцээ шаардлагыг цогц, харилцан уялдаа холбоотой бодлого, хөтөлбөрүүдтэй зүй зохистой байдлаар нэгтгэн уялдуулах нь тус хөтөлбөрөөс гарах хоёр дахь үр дүн юм. Дотоодын шилжилт хөдөлгөөний талаарх өргөн хүрээтэй мэдлэг, мэдээллийг оролцогч талуудад олгож, улмаар богино, дунд, урт хугацаат бодлогын хариу арга хэмжээний талаар бие даасан зөвлөмжүүд бүхий Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулснаар Монгол Улсын Засгийн газар нь дотоодын шилжин суурьшигчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн үр дүнтэй хариу арга хэмжээ авах, дотоод шилжилт хөдөлгөөнийг бодлого төлөвлөлт, хариу арга хэмжээнд чиглүүлэхэд шаардлагатай арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх боломжтой болно.

Гурав дахь үр дүнгээр мэдээлэл, үйлчилгээ, зорилтот арга хэмжээний хүртээмжийг сайжруулах замаар дотоодын шилжин суурьшигчдын эмзэг байдлыг багасгах зорилготой. НЗДТГ, иргэний нийгмийн байгууллагууд, үндэсний хэмжээний болон орон нутгийн түвшний засаг захиргааны байгууллагууд (хороо, аймаг, сумын ЗДТГ)-тай нягт хамтарч ажиллана. Улаанбаатар хотын шилжин суурьшигчид, хөдөө орон нутгаас шилжилт хөдөлгөөн хийхээр төлөвлөж байгаа иргэдэд шилжилт хөдөлгөөн хийх шийдвэр гаргахаасаа өмнө мэдээлэлтэй байх зорилго бүхий Мэдээллийн компанит ажлыг улс орон даяар амжилттай зохион байгуулсан.

Төслийн 3.3 дугаар хэсэгт тусгасны дагуу тус төсөл нь шилжилт хөдөлгөөн, ялангуяа шилжин суурьшиж буй эмэгтэйчүүдэд хамаатай мэдээлэл, үйлчилгээг үзүүлэх ТББ-уудын чадавхыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх болно. Энэхүү хэсэг нь Улаанбаатар болон аймгуудын хязгаарлагдмал чадавхи, нөөц бүхий хороод, орон нутгийн байгууллагад дэмжлэг үзүүлэх, улмаар Улаанбаатар хот болон цаашилаад дотоодын шилжин суурьшигчид, хөдөө орон нутагт шилжилт хөдөлгөөн хийх хүсэлтэй шилжин суурьшигчдад чиглэсэн зөвлөгөө, мэдээллээр хангах зорилготой.

Тэтгэлгийн үндэслэл, зорилго

Уг тэтгэлгийн зорилго нь дотоодын шилжин суурьшигчдыг эдийн засгийн хувьд чадавхжуулах, хөдөлмөр эрхлэх боломжийг нь нэмэгдүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах, нийгэм сэтгэлзүйн дэмжлэг (НСД) тусалцаа үзүүлэх, орон нутгийн хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан тодорхой хэсгүүдийг хэрэгжүүлэхэд орон нутгийн удирдлагууд болон ТББ-уудын хамтын ажиллагааг идэвхжүүлэн, нөөц бололцоог дэмжин ажиллахад оршино.

Тус хөтөлбөрөөр орон нутгийн ТББ-ууд орон нутгийн хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх явцад орон нутгийн төрийн байгууллагуудад (ОНТБ) үйлчилгээний ачааллыг бууруулах, шинэлэг арга зүй нэвтрүүлэх, чадамж, уян хатан байдлаа дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх

ерөнхий чиг хандлагыг баримтална.

Зорилт:

1. Шилжин суурьшсан болон цаашид шилжин суурьшихаар төлөвлөж байгаа иргэдийн мэдлэг, мэдээллийн түвшинг дээшлүүлэх: аюулгүй шилжилт хөдөлгөөн, үйлчилгээ авах боломжоор хангах зэрэг ажлуудыг хийнэ.
2. Нийгэм сэтгэл зүйн үйлчилгээ болон бусад төрлийн үйлчилгээ авах боломжоор хязгаарлагдсан шилжин ирэгсдэд нийгэм сэтгэлзүйн үйлчилгээ үзүүлнэ,
3. Үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх боломжтой арга хэмжээг боловсруулж, туршиж үзнэ,
4. Үндэсний хэмжээний бодлогыг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэхэд нэн хэрэгцээтэй, тухайн нөхцлийг сайжруулах зөвлөмжөөр хангахад тулгамдаж буй асуудлууд, саад бэрхшээлийг тодорхойлно,
5. Орон нутгийн түвшинд иргэний нийгмийн институцуудийг бэхжүүлж, орон нутгийн төрийн байгууллагуудтай хамтран ажиллана.

Тэтгэлэг

Шилжилт хөдөлгөөний талаар тодорхой түвшний ойлголттой, нэн шаардлагатай үйлчилгээ үзүүлэх шинэлэг, үр дүн бүхий төлөвлөгөөтэй, шилжин суурьшигчдад дэмжлэг туслалцаа үзүүлэх, орон нутгийн засаг захиргаанд дэмжлэг үзүүлэх, чадавх, туршилагатай орон нутгийн ТББ-уудыг урьж байна. Шилжилт хөдөлгөөн, түүнтэй холбоотой үйлчилгээ үзүүлсэн туршилага болон тус тэтгэлгийн зорилго, зорилтыг харгалзан дараах бүтэц бүхий төслийн саналтай байгууллагууд хамтран ажиллах саналаа ирүүлнэ үү.

- I. **Эдийн засгийн бүрэлдэхүүн хэсэг (хүсэлт гаргагчийн төсөвт тусгах):** шилжин суурьшсан болон шилжин ирэхээр төлөвлөж байгаа иргэдэд эдийн засгийн чадавхтай болох хөдөлмөр эрхлэх чадамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа: Явуулах боломжтой үйл ажиллагаа гэдэгт шилжин суурьшигчдад зориулсан ажилтай болох, зээл авах, бизнес эхлүүлэх зэрэг боломжуудын талаар мэдээлэл өгөх сургалт, семинар зохион байгуулах, зээлийн хөтөлбөрт хамрагдахад нь дэмжлэг үзүүлэх, тухайлбал маркетинг, нягтлан бодох бүртгэлийн тал дээр дэмжлэг болохуйц мэргэжлийн туслалцаа үзүүлэх зэрэг болно. Мөн шилжин суурьшигчдад энэхүү дурьдсан зөвлөгөө өгөх зэрэг бүхэлдээ тогтвортой ажил хөдөлмөр эрхлэх, бизнесийн үйл ажиллагаа эрхлүүлэхэд чиглэсэн ажлууд багтах ба өөр нэмэлт ажлууд байж болно.

Үндсэн шалгуур: сургагдсан хүний тоо, чадавхыг бэхжүүлэх чиглэлээр мэдлэгээ дээшлүүлсэн хүний тоо, ажилд орсон хүний тоо, бизнес эхлүүлсэн хүний тоо

- II. **Мэдээлэл, НСД үзүүлэх бүрэлдэхүүн хэсэг (төсвийн хүсэлт гаргагч боловсруулах):** шилжин суурьшигчид болон шилжин ирэхээр төлөвлөж байгаа иргэдэд зайлшгүй шаардлагатай бусад мэдээлэл, үйлчилгээгээ үзүүлэх үйл ажиллагаа. Шилжин суурьшсан иргэд болон ирэх хүсэлтэй иргэдэд тулгамдаж байгаа бэрхшээлт байдлыг бууруулах, түүнчлэн тогтвортой ажил хөдөлмөр эрхлэх, бизнесийн үйл ажиллагаа явуулахад нь чиглэсэн эдийн засгийн бүрэлдэхүүн хэсэгт гаргах ахиц дэвшилд дэмжлэг үзүүлэх нь эдгээр үйл ажиллагааны зорилго юм. Уг ажлын хүрээнд хоёр удаагийн Мэдээллийн өдөрлөгийг зохион байгуулна. Бүх сонгогдсон орон нутгийн ТББ-ууд болон НҮБ-ын Шилжилт Хөдөлгөөний Байгууллагатай хамтарч төслийн хэрэгжилтийн эхэн болон дунд үед тодорхой өдрийг сонгоно. Ингэхдээ шилжилт хөдөлгөөн хийсэн болон хийхээр төлөвлөж байгаа газрын ажил хөдөлмөр, бизнес эрхлэх боломжууд, нэн шаардлагатай зөвлөгөө зөвлөмжүүдийг нэгтгэсэн байдлаар хүргэх ба нийгэм сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ хэд хэдэн үйл ажиллагааг нэгэн зэрэг хэрэгжүүлнэ. Хоёр дахь Мэдээллийн өдөрлөг нь орон нутгийн эрэлт хэрэгцээнд илүү нийцсэн, төслийн дөрөвдүгээр хэсгийн хүрээнд хийсэн судалгаа зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх ёстой.

- III. **Боломжит ажлыг хэрэгжүүлэх бүрэлдэхүүн хэсэг (төсвийг хүсэлт гаргагч боловсруулна):** Дөрөвдүгээр бүрэлдэхүүн хэсэгт заасан судалгаа шинжилгээний

зөвлөмжийг хэрэгжүүлэхэд дэмжлэг болох үйл ажиллагаанд нийт зарцуулах төсвийн 10%-20%-ийг төсөвлөхийг санал болгож байна.

IV. **Судалгаа шинжилгээний бүрэлдэхүүн хэсэг** (ТББ болон орон нутгийн төрийн байгууллагуудын дэмжлэгтэйгээр хийх тул төсөв шаардагдахгүй): НҮБ-ын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага нь сонгогдсон орон нутгийн ТББ-ууд, ОНТБ-уудтай үйл ажиллагааны зорилтот бүс нутагт судалгаа шинжилгээ явуулахад бусад түнш байгууллагуудтай хамтран ажиллана. НҮБ-ын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага нь ерөнхий арга зүйг боловсруулан хангах, сургалт зохион байгуулах, тоон мэдээлэл цуглуулах, мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд дэмжлэг үзүүлэн ажиллана. Орон нутгийн ТББ нь орон нутгийн төрийн байгууллагатай хамтарч судалгаа шинжилгээ явуулах, шаардлагатай мэдээлэл цуглуулах, ба судалгаа шинжилгээнээс гарсан зөвлөмжүүдийн хэрэгжилтийг мөрдүүлнэ.

Үндэслэл, зорилго

Тэтгэлгийн үндэслэл, зорилго

Уг тэтгэлгийн зорилго нь дотоодын шилжин суурьшигчдыг эдийн засгийн хувьд чадавхжуулах, хөдөлмөр эрхлэх боломжийг нь нэмэгдүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах, нийгэм сэтгэлзүйн дэмжлэг (НСД) тусалцаа үзүүлэх, орон нутгийн хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан тодорхой хэсгүүдийг хэрэгжүүлэхэд орон нутгийн удирдлагууд болон ТББ-уудын хамтын ажиллагааг идэвхжүүлэн, нөөц бололцоог дэмжин ажиллахад оршино.

Тус хөтөлбөрөөр орон нутгийн ТББ-ууд орон нутгийн хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх явцад орон нутгийн төрийн байгууллагуудад (ОНТБ) үйлчилгээний ачааллыг бууруулах, шинэлэг арга зүй нэвтрүүлэх, чадамж, уян хатан байдлаа дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх ерөнхий чиг хандлагыг баримтална.

Зорилт:

1. Шилжин суурьшсан болон цаашид шилжин суурьшихаар төлөвлөж байгаа иргэдийн мэдлэг, мэдээллийн түвшинг дээшлүүлэх: аюулгүй шилжилт хөдөлгөөн, үйлчилгээ авах боломжоор хангах зэрэг ажлуудыг хийнэ.
2. Нийгэм сэтгэл зүйн үйлчилгээ болон бусад төрлийн үйлчилгээ авах боломжоор хязгаарлагдсан шилжин ирэгсдэд нийгэм сэтгэлзүйн үйлчилгээ үзүүлнэ,
3. Үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх боломжтой арга хэмжээг боловсруулж, туршиж үзнэ,
4. Үндэсний хэмжээний бодлогыг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэхэд нэн хэрэгцээтэй, тухайн нөхцлийг сайжруулах зөвлөмжөөр хангахад тулгамдаж буй асуудлууд, саад бэрхшээлийг тодорхойлно,
5. Орон нутгийн түвшинд иргэний нийгмийн институцуудыг бэхжүүлж, орон нутгийн төрийн байгууллагуудтай хамтран ажиллана.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаанууд

Орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх зорилтот арга хэмжээ нь орон нутгийн шилжилт хөдөлгөөний нөхцөл байдлаас хамаарч харилцан адилгүй байдаг тул хүсэлт гаргагчид орон нутгийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн үйл ажиллагааг санал болгох нь зүйтэй.

Орон нутгийн нөхцөл байдал, шаардлагаас хамаарч ТББ-уудын хэрэгжүүлж болох үйл ажиллагаануудад:

- Зайлишгүй шаардлагатай мэдээллээр хангах, олон нийтийг хамарсан арга хэмжээ / нээлттэй хаалганы өдөрлөг, мэдээллээр хангах аян;
- Шилжин суурьшигчдад зориулсан зайлишгүй шаардлагатай үйлчилгээнд хамруулах, дэмжлэг үзүүлэх;
- Нийгэм сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх;
- Хэрэгцээ шаардлагад нь нийцсэн богино хугацаат сургалтууд зохион байгуулах;

- *Ажлын байр бий болгох төслүүд, шилжин суурьших, шилжилт хөдөлгөөн хийх бүс нутагт жижиж бизнес эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүд хэрэгжүүлэх;*
- *Угтах үйлчилгээ үзүүлэх ажлууд багтана.*

Жич: Санал болгож буй эдгээр үйл ажиллагааг заавал оруулах албагүй ба тухайн орон нутаг, аймаг, сум, дүүрэг, хорооны нөхцөл байдал, онцлогт тохируулж болно.

Хамтын ажиллагаа

Орон нутгийн түвшинд иргэний нийгмийн институцуудийг бэхжүүлж, орон нутгийн төрийн байгууллагуудтай хамтран ажиллана.

Хэрэгжүүлэх хугацаа

Тус төсөл нь 2022 оны 06 дугаар сарын 15-наас эхлэн 6 сарын хугацаанд хэрэгжинэ

Тавигдах шалгуур

• Хүсэлт гаргах ТББ-д тавигдах шалгуур:

- *Монгол Улсад бүртгэлтэй, санал болгож буй бүх үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх зүйн чадамжтай;*
- *Зорилтот бүлэгтэй ажиллаж байсан туршилагатай байх, дотоодын шилжин суурьшигчидтай ажиллаж байсан бол давуу тал гэж үзнэ;*
- *Орон нутгийн төрийн байгууллага, үндэсний болон орон нутгийн ТББ-ууд, бусад байгууллага, хувь хүмүүстэй түншлэлийг бий болгож, хамтран ажиллаж байсан туршилагатай байх.*

Хүсэлт гаргагч ТББ нь:

- *Тус төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай чадварлаг, мэргэшсэн багийн гишүүдтэй байх;*
- *НҮБ-ын Шилжилт Хөдөлгөөний Байгууллагатай хамтран ажиллаж байсан туршилагатай бол давуу тал болно. Өмнө нь хамтран ажиллаж байсан бол үйл ажиллагааны үр дүнтэй, тайлагнаж байсан гэх зэрэг сайн түүхтэй байх. Төсөл дууссаны дараа орон нутгийн төрийн байгууллагуудтай хамтран тус төслийг үргэлжлүүлэх төлөвлөгөө, бололцоотой байх.;*
- *Орон нутгийн төрийн байгууллагатай хамтран ажиллах, санхүүжилтийг баталгаажуулсан байх;*
- *НҮБ-ын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага тэргүүлж байгаа дотоод шилжилт хөдөлгөөний чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг орон нутгийн ТББ-уудын Сүлжээнд нэгдэн идэвхтэй үйл ажиллагаа явуулах зорилготой байх;*
- *Дотоод шилжилт хөдөлгөөний чиглэлээр хэрэгжиж байгаа нэгдмэл зорилгуудыг дэмжих бусад үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;*
- *НҮБ-ын Шилжилт хөдөлгөөний байгууллагатай бүх талаар хамтран ажиллах, хугацаат ажлыг хугацаанд нь гаргаж өгөх, зайлигүй шаардлагатай бүх мэдээллийг хугацаанд нь ирүүлэх.*

Хүсэлт гаргагч дараах шаардлагыг хангасан байх:

- *Саналыг бүрэн боловсруулж дуусгасан байх;*
- *Саналын бүх хэсгүүдийг төслийн менежментийн үүднээс логикийн байдлаар нэгтгэсэн байх;*
- *Төслийн зорилго, зорилт, үр дүн, гаргалгаа нь үндэслэлтэй тооцоолон гаргасан хугацаатай; биелүүлэх боломжтой, хүртээмжтэй байх ба шаардлагатай бүх хэсэг, маягтуудыг бөглөсөн байх;*
- *Санал нь шилжилт хөдөлгөөний агуулгын хэтийн төлөвийг тод томруунаар авч үзсэн байх;*
- *Саналыг орон нутгийн төрийн байгууллагатай хамтран боловсруулсан байх;*
- *Хэрэгжүүлэх арга хэмжээний тодорхой хэсгийг орон даяар өргөжүүлэх боломжтой байх*

Материал хүлээн авах эцсийн хугацаа

Төслийн саналыг 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрөөс өмнө iomubadminhr@iom.int цахим хаягаар болон цаасан хэлбэрээр дараах шуудангийн хаягаар илгээнэ:

*Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага, Нэгдсэн Үндэстний Байгууллага,
Нэгдсэн Үндэстний гудамж-14, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14201*

Төслийн саналын бүтэн хувилбарыг <https://mongolia.iom.int/> цахим хуудаснаас авах боломжтой.

Загвар А: Төрийн бус байгууллагын танилцуулга

ОРОН НУТГИЙН ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ, ДОТООДЫН ШИЛЖИН СУУРЬШИГЧДАД ЗОРИУЛСАН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

Нүүр хуудас

БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ

Байгууллагын нэр:

Аймаг:

Удирдах албан тушаалтны нэр:

Албан тушаал:

Хаяг:

Утас:

И-мэйл:

ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр:

Хэрэгжих хугацаа:

Төслийн нийт төсөв:

ЖТТ-ын хүрээнд шаардагдах төсөв:

ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН СТРАТЕГИ

Төслийн дараах үйл ажиллагаа, тэр дундаа орон нутгийн төрийн байгууллагын хариуцсан үйл ажиллагаа хэрхэн үргэлжлэх төлөвлөгөө:

.....
.....

БАГИЙН ГИШҮҮДИЙН CV ЭСВЭЛ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА БОЛОН ТЭДНИЙ МЭРГЭШСЭН БАЙДАЛ

(Гишүүн тус бүрийн анкетыг хавсаргаж оруулна).

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

(Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг хавсаргаж оруулна).

Баталгаажуулалт

Энэхүү төслийн үйл ажиллагаа, үр дүн хэрэгжилтийг тус байгууллагын нэрийн өмнөөс хариуцан ажиллах, холбоо тогтоох гол хүн болохоо үүгээр илэрхийлж байна.

Нэр:

Албан тушаал:

Гарын үсэг:

Тамга:

Загвар Б Өргөдлийн маягт

ОРОН НУТГИЙН ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ, ДОТООДЫН ШИЛЖИН СУУРЬШИГЧДАД ЗОРИУЛСАН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

ӨРГӨДЛИЙН МАЯГТ

1. Төслийн талаарх товч мэдээлэл

Энэ хэсэгт санал болгож буй төслийн талаар товч мэдээллийг оруулна уу. Төслийн зорилго, зорилт, цаг хугацаа, үр шим хүртэгчид болон үр дүнг тодорхой бичнэ үү. /A4-ийн тал нүүрнээс илүүгүй байх/. Төслийн хугацаа дуусгавар болсон ч энэхүү төслийн зорилго, зорилт үйл ажиллагаа, үр дүн нь цаашид хэрхэн тогтвортой байдлыг хангах талаар тусгаж өгвөл давуу тал болно.

2. Хэрэгцээ шаардлага /нөхцөл байдлын дүн шинжилгээ/

Энэ хэсэгт асуудал болон тухайн асуудлыг хэрхэн яаж шийдэх талаар бичнэ үү. Шаардлагатай бол тоо, статистик болон бусад дэмжих мэдээллийг оруулна уу. /A4-ийн тал нүүрнээс илүүгүй байх/

3. Зорилго болон үр дүн

Төслийн зорилгоо товч бөгөөд тодорхой бичнэ. Зорилго нь тухайн төслийн цаг хугацаа, хүний нөөц болон төсөвтэй нягт уялдаа холбоотой байна. Төслийг хэрэгжүүлснээр ямар үр дүнд хүрэх, хэнд, ямар хугацаанд бодит өөрчлөлтийг бий болгох талаар тодорхой тусгана. Энэхүү үр дүн нь ямар үр нөлөөг бий болгох талаар оруулж өгнө.

4. Үйл ажиллагааны төлөвлөгөө

ХАВСРАЛТ 1-ыг харна уу.

5. Төсөл хэрэгжүүлэх баг

Төслийн баг болон тэдний төслийн хүрээнд хариуцах чиг үүрэг, оролцоог бичнэ үү.

6. Хяналт ба Үнэлгээ

Загвар В-г харна уу.

7. Төсөв

Загвар Г-г харна уу.



International Organization for Migration (IOM)
The UN Migration Agency

Хавсралт 1:ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Зорилт	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн	Үр дүн
1-үе шат төслийн бэлтгэл, зохион байгуулалт					
1.	1.				
2-р үе шат Төслийн үндсэн үйл ажиллагаа					

2					
2					
3					
3-р үе шат Төгсгөлийн хэсэг					

Загвар В: Гүйцэтгэлийн үзүүлэлт, зорилтыг Хянах, Үнэлэх аргачлал

ОРОН НУТГИЙН ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ, ДОТООДЫН ШИЛЖИН СУУРЬШИГЧДАД ЗОРИУЛСАН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

Хяналт үнэлгээний төлөвлөгөө

Зөвлөмж:

- Төслийн үйл ажиллагаанаас үүдэн нэмэлт мэдээлэл оруулж болно. Нэгдсэн шугамаар мэдээлэл авсны дараа Хяналт, үнэлгээний төлөвлөгөөг төслийн ерөнхий шаардлага, хүрэх гэж байгаа үр дүнтэй уялдуулан шинэчилнэ. Бодитой байх үүднээс кейсүүд болон үйлчилгээ авч амьдралд нь өөрчлөлт орсон хүний бодит түүх, сонирхол татсан баримтаар баяжуулж болно.

Зорилго	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	БАТАЛГААЖУУЛАЛТ/ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ АРГА	СУУРЬ МЭДЭЭЛЭЛ	ХҮРЭХ ҮР ДҮН
			Сургалтад хамрагсан хүмүүсийн тоо (хүйсээр ангилсан) Зураг Бодит кейс, сонирхолтой түүх Байршуулсан төсвийн хэмжээ Зурагдсан гэрээ Ажлын төлөвлөгөө		

ТӨСӨВ

Хэрэгжүүлэгч;	
Төслийн нэр;	
Төслийн хугацаа;	
Төсөлийн валют;	

№	Зардлын нэр/төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн зардал	ТББ-аас оруулах хувь нэмэр	Орон нутгаас гарах зардал	Нийт зардал
Зардлын бүлгээр хуваана (Жишээ нь: цалингийн зардал)							
1							-
3							-
5							-
7							-
9							-
11							-
13							-
14							-
15							-
16							-
17							-

18							-
19							-
				Дүн			-
Зардлын бүлгээр хуваана (Жишээ нь: үйл ажиллагааны зардал)							
1							-
3							-
5							-
7							-
9							-
11							-
13							-
14							-
15							-
16							-
17							-
18							-
19							-
				Дүн			-
Зардлын бүлгээр хуваана (Жишээ нь: оффисийн зардал)							
1							-
2							-

3							-
4							-
5							-
6							-
7							-
8							-
9							-
10							-
11							-
12							-
13							-
14							-
15							-
16							-
17							-
18							-
19							-
20							-
				Дүн			-
Нийт дүн (төгрөгөөр)							-

Загвар Д: Төсөл хэрэгжүүлэгчийн ерөнхий мэдээлэл /асуулга/

НҮБ-ын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага – Монгол улс дахь салбар

Сонгон шалгаруулалтын оролцох урилга #:

Төсөл хэрэгжүүлэгчийн ерөнхий мэдээлэл /асуулга/

Байгууллагын РД:	
Байгууллагын бүтэн нэр, товчилсон нэр:	
Хаяг, холбогдох субъектийн утасны дугаар:	
Материал илгээсэн огноо:	
Урьд нь ОУШХБ-тай хамтран ажиллаж байсан эсэх?	
Урьд нь ОУШХБ-тай хамтран ажиллаж байсан огноо:	

А. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ БОЛОН ЗАСАГЛАЛ

Танай байгууллага улсын бүртгэлд бүртгэлтэй юу? Бүртгэлтэй бол улсын баталгаат баримт бичгийг хүргүүлнэ үү. Үгүй бол тайлбарыг бичнэ үү.	
Хуулийн этгээдийн төрөл: Олон улсын байгууллага, ТББ, гэх мэт	
Танай байгууллага жил бүр аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг олон нийтэд нээлттэй гаргадаг үү? Үгүй бол тайлбарлана үү.	
Танай байгууллагын удирдлагад, ОУШХБ-тай ямар нэгэн ашиг сонирхлын холбоотой субъект байдаг үү?	
Байгууллагын эрх бүхий албан тушаалтан	
Байгууллагын үүсгэн байгуулагдсан огноо	
НҮБ болон ОУШХБ-д ямар нэгэн байдлаар хандаж байсан, эсвэл үнэлгээ авч байсан бол тус огноог бичнэ үү	
НҮБ олон ОУШХБ-аас дүгнэсэн үнэлгээг оруулна үү	

В. БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ

Байгууллагын хамгийн сүүлд батлагдсан бүтэц, үндсэн ажилтнуудын CV-г өргөдөлд хавсаргана үү	
Байгууллагын аль улсад үйл ажиллагаа явуулдаг вэ?, тус улсад ажиллах байдлын талаар	
Бүртгэлтэй улсад байршин ажилладаг ажилтны тоо	
Үйл ажиллагааны үндсэн чиг үүргийн дагуу хангалттай боловсон хүчин, хүний нөөцөөр хангагдсан эсэх? /санхүү, хангамж, тээвэрлэлт, төслийн хэрэгжилт/	

Байгууллага дотоо журамтай юу?	
Байгууллага аюулгүй ажиллагаанд мөрдөх журамтай юу	
С. ГАДНЫ ОРОЛЦОО, НӨЛӨӨЛӨЛ	
Хамтран ажилладаг байгуулагууд	
Байгууллага нь иргэний нийгмийн байгууллага, хүмүүнлэгийн байгууллагуудтай холбоо тогтоож байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй мэдээлэл оруулна уу.	
Байгууллага нь бусад Иргэний нийгмийн байгууллагуудтай (орон нутаг, үндэсний, олон улсын) хамтран төсөл хэрэгжүүлдэг үү? Хэрэв тийм бол дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү.	
Байгууллага нь ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй иргэний нийгмийн болон бусад байгууллагуудтай хэрхэн хамтран ажилладаг вэ?	
Төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж байсан үү ?	
Байгууллага нь олон нийтийн болон улс төрийн үйл явцад оролцдог үү (жишээлбэл, үндэсний болон орон нутгийн засгийн газрын бодлого, төсвийн хэлэлцүүлэг / шийдвэр) гэх мэт	
Мэдээлэл болон нөлөөллийн ажил	
Байгууллага нь тогтмол мэдээлэл гарган ажилладаг үү ? тийм бол дэлгэрэнгүй тайлбарлана уу	
Байгууллага хандив цуглуулах болон бусад зорилгоор олон нийтийн арга хэмжээ зохион байгуулдаг үү? Хэрэв тийм бол тайлбарлана уу.	
Байгууллага нь хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажилладаг үү ?	
Байгууллага нь төсөл хэрэгжүүлэхдээ нөлөөллийн аян хэрэгжүүлдэг үү? Хэрэв бол дэлгэрэнгүй бичнэ үү.	
Байгууллага нь Лобби хэрэгжүүлж ажилладаг үү. Хэрэв тийм бол дэлгэрэнгүй бичнэ үү.	
С. ТӨСӨЛ хэрэгжүүлэх чадавх	
Байгууллага нь тодорхой зорилго, алсын хараатай юу? Нээлттэй байршуулсан бол линкийг оруулна уу	
Байгууллагын зорилтот бүлэг(үүд)/ үр шимийг хүртэгчид юу вэ?	
Байгууллагын төсөл хэрэгжүүлэх зорилтот байршил	
Байгууллагын төсөл хэрэгжилтийн хөтөлбөрт юу анхаардаг вэ ?	
Байгууллагын эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийн удирдлагын үйл явцыг баримтжуулсан байдаг үү ?	
Байгууллагын асуулга:	

Хүмүүнлэгийн байгууллагын үндсэн дүрмүүдийг дагаж мөрддөг үү?	
Зөвхөн хэрэгцээ шаардлагад тулгуурлан шударга бус тусламж үзүүлэхийг дэмжих үү?	
Улс төрийн зорилгоос хараат бусаар бие даан ажиллах үү?	
Хор хөнөөл учруулахгүй байх хандлагыг баримтлах үү?	
Урт хугацааны төлөвлөгөө/стратеги бий юу?	
Нөлөөлөлд өртсөн ажилтанд хариуцлага тооцох тогтолцоо бий юу?	
Ёс зүйн дүрэм эсвэл бусад ёс зүйн бодлого байна үү?	
Бэлгийн мөлжлөг, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх бодлого, журамтай юу?	
D. САНХҮҮГИЙН ЧАДАВХ	
Одоогоор ямар хандивлагчид байгууллагын хөтөлбөрийн үйл ажиллагааг дэмжиж байна вэ?	
Одоогийн байдлаар байгууллагын үйл ажиллагааны нийт төсөв хэд вэ?	
Байгууллага сүүлийн гурван жилийн хугацаанд хөрвөх чадвар, төлбөрийн чадвартай холбоотой ямар нэгэн бэрхшээлтэй тулгарсан үү? Хэрэв тийм бол яаж шийдсэн бэ?	
САНХҮҮГИЙН БҮРТГЭЛИЙН СИСТЕМ	
Байгууллага нягтлан бодох бүртгэлийн стандарт, дүрэм, журмыг баримтжуулсан нарийвчилсан бодлоготой юу?	
Байгууллага нягтлан бодох бүртгэлийн ямар стандартыг мөрддөг вэ (УСНББОУС; СТОУС, үндэсний)?	
Байгууллага нягтлан бодох бүртгэлийн ямар программ хангамжийг ашигладаг бөгөөд энэ нь бусад функцуудтай (жишээ нь хүний нөөц, худалдан авалт гэх мэт) нэгдсэн үү?	
Нягтлан бодох бүртгэл, дагалдах баримт бичигтэй холбоотой баримт бичгийн хадгалалтын бодлого юу вэ? Байгууллага архивыг хулгай, гал түймэр, үер гэх мэт зүйлээс хэрхэн хамгаалдаг вэ? Сүүлийн гурван жилийн хугацаанд энэ тал дээр ямар нэгэн бэрхшээл тулгарсан үү?	
Байгууллагын дансанд бүх зардлыг цаг тухайд нь бүртгэсэн үү?	
Байгууллага төслийн түвшинд үе үе санхүүгийн тайлан гаргаж чадах үү?	
САНХҮҮГИЙН УДИРДЛАГА	
Байгууллага өөрийн нэр дээр бүртгэлтэй өөрийн данстай юу?	

Байгууллагад дотоод аудитын чиг үүрэг бүхий бүтэц бий юу?	
Байгууллагын дансанд хөндлөнгийн аудит хийх тогтмол шаардлага байдаг уу, хэрэв тийм бол цаг тухайд нь хийж байна уу?	
Байгууллага аудитын зөвлөмжийг дагаж мөрддөг үү?	
Дотоод хяналтын тогтолцооны гол шинж чанарууд юу вэ? Сүүлийн гурван жилийн хугацаанд энэ тал дээр ямар нэгэн бэрхшээл тулгарсан уу?	
Байгууллага ажил үүргийн хуваарилалтыг хэрхэн хангадаг вэ?	
Хандивлагчдад зардлаа давхар тайлагнадаггүй тогтолцоо бий юу? Байгууллага холбогдох хяналтыг хөнгөвчлөх төслийн нягтлан бодох бүртгэлийн шийдэлтэй юу?	
ЗАРДЛЫН ТООЦОО, ҮР АШИГ	
Байгууллага зардлаа тооцдог уу? Зардлаа багасгахын тулд ямар зарчмуудыг баримталдаг вэ?	
Худалдан авалт хийхээс өмнө үнийн санал эсвэл нэхэмжлэх цуглуулдаг уу?	
Е. ХУДАЛДАН АВАЛТЫН ПРОЦЕСС, СҮЛЖЭЭ	
Байгууллагын худалдан авалтын болон логистикийн процессыг тайлбарлана уу.	
Тус байгууллага нь террористуудын хүлээн зөвшөөрөгдсөн жагсаалтын эсрэг түншүүд болон ханган нийлүүлэгчдийг системтэйгээр шалгахыг шаарддаг терроризмын эсрэг бодлоготой бөгөөд үүнийг дагаж мөрддөг үү?	
ХАНГАМЖ	
Байгууллага худалдан авах ажиллагааны тодорхой журамтай юу? Хэрэв тийм бол хуулбарыг илгээнэ үү	
Байгууллагын худалдан авах ажиллагааны бодлогыг бусад байгууллага болон/эсвэл хандивлагчид хянаж, хүлээн зөвшөөрсөн үү?	
Худалдан авах ажиллагааны явцад ажил үүргийн хуваарилалт, эрх мэдлийг шилжүүлэх тодорхой бодлого тус байгууллагад бий юу?	
Байгууллага нь худалдан авалтын төлөвлөгөөтэй юу? (түүнийг ашигладаг) үү?	
Байгууллага худалдан авалтын гүйлгээг бүртгэхдээ ERP системийг ашигладаг үү?	
Хөрөнгө, агуулахын менежмент	
Байгууллага хөрөнгийн мэдээллийн сантай юу?	
Байгууллагад эд хөрөнгийг хүлээлгэн өгөх, хасах, худалдах, захиран зарцуулах протокол бий юу?	

Байгууллагад нөөц, агуулахыг удирдах журам байдаг уу?	
--	--

Доор гарын үсэг зурсан би энэ маяганд оруулсан мэдээлэл үнэн зөв гэдгийг баталж байна. Энэхүү мэдээлэлд өөрчлөлт орсон тохиоллолд даруй мэдээлэх үүрэг хүлээнэ.

_____ Нэр/ Гарын үсэг/ Он сар өдөр